

## **ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2026 оны ... сарын...өдөр

Дугаар

Улаанбаатар хот

### **Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай**

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.9.8 дахь заалт, 16 дугаар зүйлийн 16.1.6 дахь заалт, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 18.2 дахь хэсэг, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсэг, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2026 оны “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 07 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтын 3 дахь хэсгийн 3.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2026 оны 07 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсан Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах тусламж, үйлчилгээний суурь тарифын хэмжээ тогтоосон хүснэгтийг хавсралт хүснэгтийн дагуу өөрчилсүгэй

2. Тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар баталсан “Төрөөс төлбөрийг нь хариуцах эмийн зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.5.4 дэх хэсэгт “Эмийн гаалийн үнээс тодорхой хувийн нэмэгдэл тооцон дээд хязгаар тогтоох ба хэтэрсэн тохиолдолд зөрүүг санхүүжүүлэхгүй. Нэмэгдэл хувийг тогтоохдоо тусламж, үйлчилгээний тасалдалгүй байдал, төсвийн үр ашигтай зарцуулалт, үнийн хиймэл хөөрөгдөл, өмнөх онуудын нэхэмжлэлийн түүх зэрэг хүчин зүйлсийг нэгэн зэрэг харгалзан үзнэ.” гэж нэмсүгэй.

3. Энэ тогтоолыг 2026 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлэн, холбогдох арга хэмжээг авч ажиллахыг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга (Н.Эрдэнэбаяр)-д, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар (Ц.Батбаатар)-т, Эрүүл мэндийн байгууллагын дарга /захирал/ нарт даалгасугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын алба (Ц.Сарантуяа), Эрүүл мэндийн яамны Салбарын хяналт, дотоод аудит, хяналт шинжилгээ, үнэлгээний газар (С.Төгсдэлгэр)-т нарт тус тус даалгасугай.

**ГАРЫН ҮСЭГ**

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2026  
оны ...дугаар сарын ..өдрийн ...тогтоолын хавсралт

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГААС ЗАРДЛЫН ТӨЛБӨРИЙГ НЬ  
ХАРИУЦАХ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СУУРЬ ТАРИФ, ТУСЛАМЖ,  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРЛӨӨР**

| <b>№</b> | <b>Тусламж, үйлчилгээний нэр төрөл</b>                     | <b>Суурь тариф /төгрөг/</b> |
|----------|------------------------------------------------------------|-----------------------------|
| 1        | Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ                        | 1,072,628                   |
| 2        | Амбулаторийн үзлэг, хяналт, эмчилгээ, оношилгоо, шинжилгээ | 37,858                      |
| 3        | Яаралтай тусламж, үйлчилгээ                                | 107,263                     |
| 4        | Түргэн тусламж, үйлчилгээ                                  | 56,786                      |
| 5        | Телемедицин                                                | 61,236                      |
| 6        | Өдрөөр үзүүлэх тусламж, үйлчилгээ                          | 283,046                     |
| 7        | Сэргээн засах тусламж, үйлчилгээ                           | 825,552                     |
| 8        | Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ                              | 1,037,837                   |
| 9        | Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээ                | 530,712                     |
| 10       | Сувиллаас үзүүлэх тусламж, үйлчилгээ                       | 294,840                     |